



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/37

Батширээт сум

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэн,
тэмцэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.10, 18.2.12, 18.2.14, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Улсын онцгой комиссын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нийт нутаг дэвсгэрт хуурайшилтын зэрэг өндөр байгаа тул 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд ойд мод бэлтгэх, дагалт баялаг ашиглах, аялал зугаалга, ан агнах, ил задгай гал түлэх болон бусад үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарласугай.

2. Ойн мэргэжлийн байгууллагуудтай гал түймрээс хамгаалах тухай хариуцлагын гэрээг байгуулж мод бэлтгэх ажилд хяналт тавьж ажиллахыг сум Дундын Ойн ангийн даргын албыг хавсран гүйцэтгэгч (Г.Гантуяа), Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Б.Мөнх-Очир) болон бүх шатны байгаль хамгаалагч нарт даалгасугай.

3. Гал түймэр гарах эрсдэл өндөртэй газруудад хяналтыг өндөржүүлэн, хөдөлгөөнт эргүүл зохион байгуулж, ой хээрийн түймэр болон бусад гамшгийн үед ажиллах хүн хүч, тээврийн хэрэгслийг томилгоожуулан, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн дарга, Засаг даргын орлогч (Б. Төрмөнх), бүх багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган, 7 хоног тутам мэдээлэл өгч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Бүдханд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501079